



САНЖИЙН БАТСҮХ

Улаанбаатар хотын захиргааны дарга
1926-1927 он

Богд хан уулын аймаг /хуучин Түшээт хан аймаг/ Хунцалцавчид уулын хошуу, одоогийн Төв аймгийн Дэлгэрхаан сумын харьяат, 1901 онд төрсөн. Багадаа бичиг үсэгт гэрээр суралцсан.

1924 оноос хотын захиргаанд ажиллаж Сүхбаатарын нэрэмжит төв клубт сурган гэгээрүүлэх бүлгэмд суралцаж, дараа нь хотын захиргааны орлогч даргаар ажилласан.

1926 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 23 дугаар тогтоолын дөрөвдүгээр зүйлээр хотын захиргааны даргаар томилогдон мөн оны 12 дугаар сард хуралдсан хотын төлөөлөгчдийн II их хуралд хотын захиргааны ажлын тайлан тавьж хэлэлцүүлж их хурлаас хотын захиргааны дарга, мөн Улаанбаатар хотын улсын III их хурлын төлөөлөгчөөр сонгогджээ.

Улсын III, IV их хуралд хотын захиргааны ажлын тайланг тавьж асуудал оруулж байсны гадна мөн улсын VIII бага хуралд хотын захиргааны ажлын талаар илтгэл тавьсан байна.

С.Батсүх хотын захиргааны даргаар ажиллаж байгаад Засгийн газрын хэрэг эрхлэх товчооны 1927 оны 186 дугаар тогтоол, хотын дөрөвдүгээр их хурлаас чөлөөлөгджээ

